



АТАР-ӨРГӨӨ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 30 өдөр

№ 25/04

Улаанбаатар хот

ХОЙШЛОГДСОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ДАХИН ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.3, 60.4, 67 дугаар зүйлийн 67.1, 67.3, 69 дүгээр зүйлийн 69.1, 69.3, 69.6, Компанийн дүрмийн 7.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоол, Тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай” тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Атар өргөө” ХК-ийн Хойшлогдсон Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит хурлыг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 08:30 цагаас компанийн байр (Хан-Уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө 20, “Атар өргөө” ХК-ийн байрны хурлын танхим)-д хуралдуулсугай.
2. Хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:
 - Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
 - Компанийн 2024 оны жилийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах
 - Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах
1. Хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг дахин хуралдуулахаар хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст даалгах нь:
 - Компанийн хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг дахин хуралдуулах тухай зар мэдээг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл (өдөр тутмын сонин, телевиз) болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудас бусад мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх
 - Хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг дахин зарлан хуралдуулах тухай мэдэгдлийг холбогдох бичиг баримтын хамт Санхүүгийн

зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэх

- Хурлаас хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл болон хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичиг, Хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг дахин хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол болон холбогдох бусад албан бичгүүдийг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс мөн оны 05 дугаар сарын 15-ний өдрийн 10-13, 14-17 цагуудад компанийн байранд хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, саналын хуудсаар санал авах
2. Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг дахин хуралдуулахаар зарласан хугацаанд хувьцаа эзэмшигчдэд дор дурдсан баримт бичгийг танилцуулахыг хуралд бэлтгэх зохион байгуулах комисст зөвшөөрсүгэй. Үүнд:
- Компанийн 2024 оны жилийн санхүүгийн тайлан
 - Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудиторын дүгнэлт
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга
 - Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин, урамшуулал
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд холбогдох бусад мэдээлэл
 - Хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг дахин хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол болон холбогдох бусад баримт бичгүүд
3. Ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хорооны 2025 оны 03 дугаар сарын 17 өдрийн 01 дугаар шийдвэрийг үндэслэн Хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар Ц.Энхтүвшин, гишүүнээр А.Бадамгарав, Д.Гүнжмаа нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.МӨНХДАЛАЙ